

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ДҮРЭМ

Хүний нөөцийн мэргэжилтэн М.Оюун-Ундрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ дүрмийн зорилго нь өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага /цаашид "ажил олгогч" гэнэ/-д гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийг судалж бүртгэх, тайлагнах, мэдээлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхдээ Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг мөрдөнө.
- 1.3. Энэ дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогч, иргэд, хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн ажил олгогч нэгэн адил мөрдөнө.

- 1.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажиллах аргачилсан зааврыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, мөрдүүлнэ.
- 1.5. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэн (цаашид "осолдогч" гэнэ)-ийг эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, эмнэлэгт хүргэх, эрүүл мэндийн яаралтай шинжилгээ хийлгэх болон осол, хордлогоос бий болсон аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд шаардлагатай зардлыг осол, хурц хордлого гарсан тухайн ажил олгогч бүрэн хариуцна.
- 1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29.2-т заасны дагуу ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлан бүртгэсэн акт, дүгнэлт гаргах эрх, үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулна.

- 1.7. Иргэн, хуулийн этгээд тэдгээрийн хооронд гэрээгээр ажил гүйцэтгэх үед болон машин механизм, тоног төхөөрөмжийг түрээслэх, бусад хэлбэрээр ашиглах явцад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх талаар гэрээндээ тодорхой тусгасан байна. Хэрэв энэ талаар гэрээнд тусгаагүй тохиолдолд ажил гүйцэтгүүлэгч нь судлан бүртгэнэ.
- 1.8. Батлан хамгаалах, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон тахарын албанд гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг энэ дүрмийн дагуу судлан бүртгэнэ.

- 1.9. Ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ зам тээврийн осолд орсон тохиолдолд ослыг замын цагдаагийн байгууллагын дүгнэлтийн дагуу хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч судалж баталгаажуулна.
- 1.10 Тусгай зөвшөөрлийн дагуу гадаадад ажиллах хүч гаргаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаар зуучлуулсан иргэн гадаадад ажиллаж байхдаа үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд осолтой холбоотой нөхөн төлбөрийн асуудлыг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага тухайн оронд мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Гадаадад ажиллаж байхдаа үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэн нь хоёр улсын хооронд байгуулсан гэрээний дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан бол эх орондоо ирсэнээс хойш 6 сарын дотор осол, хурц хордлогын холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн харъяалах аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст гаргаж шийдвэрлүүлнэ.

Хоёр. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх

- 2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1- д заасан хөдөлмөр эрхлэгч хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртсөний улмаас гэмтэх, өвчлөх, амь насаа алдсан дараах тохиолдолд заасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэж акт тогтооно.
- 2.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д заасан ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэж байх үед;
- 2.1.2 ажил олгогчийн болон эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу албан томилолт, дайчилгаагаар бусад газарт ажил үүрэг гүйцэтгэх үед;
- 2.1.3. ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд байнга явж ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтан ажлын цагаар бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;

- 2.1.4. ажилтан ажил эхлэхийн өмнө болон ажил дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх, ажлын байрандаа амарч байх үед;
- 2.1.5. ажилтан ажилдаа ирэх, буцах замдаа /ажлын байр болон ажилтай холбоотой сургалтанд оролцож буй, түр болон байнга оршин суудаг газар, голлон хооллодог, цалингаа авдаг газрын хооронд/ бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед; Тайлбар: Энэ ослыг судлан бүртгэхдээ 2.1.5.-д дурьдсан нөхцөл байдлын чиглэл, маршрут, цаг хугацаа зэргийг үндэс болгоно.
- 2.1.6. ажил үүргээ гүйцэтгэх үедээ байгаль, цаг уур, гал, усны гэнэтийн аюул, цацраг идэвхит болон химийн бодисын нөлөөлөл, биологийн гаралтай гоц халдварт өвчин үүсгэгч, хөнөөх хэрэгсэл, сүйрэл, дэлбэрэлтийн үед зэрэг болно.
- 2.2. Орон тооны бус байнгын комисс нь осолдогч согтууруулах ундаа мансууруулах бодис хэрэглэсний болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг санаатай зөрчсөний улмаас осолд өртсөн, гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн биед гэмтэл учруулсан нь нотлогдсон тохиолдолд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн актад энэ тухай тусгайлан тэмдэглэнэ.

Гурав. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулах

- 3.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс (цаашид комисс гэнэ)-ыг ажил олгогчийн болон ажилтны төлөөлөл бүхий 3-аас доошгүй гишүүдтэй байгуулж, комиссын даргыг ажил олгогч шийдвэр гаргаж томилно.
- 3.2. Хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээгээр ажил, үүрэг гүйцэтгэх үед болон жижиг дунд үйлдвэр, хувиараа хөдөлмөр эрхлэгч, хоршоо нөхөрлөлийн гишүүн хөдөлмөр эрхлэх явцад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан (тамгын газраас нэг, ажил олгогч болон ажилтны төлөөллөөс тус бүр хоёр хүний бүрэлдэхүүнтэй) комисс тухайн гарсан осол, хордлогыг судлан бүртгэж, акт тогтооно.

- 3.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын онцлог, бий болсон нөхцөлөөс хамааран энэ дүрмийн 3.1, 3.2-т заасан комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.
- 3.4. Томилолт, гэрээ, дайчилгааны дагуу өөр байгууллагад ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба болон цагдаагийн байгууллагын ажилтан, цэргийн жинхэнэ алба хаагч, цэргийн сургуулийн сонсогч, хоригдол, дадлага хийж байгаа оюутан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд түүнийг осол гаргасан ажил олгогчид хамааруулан бүртгэх ба энэ дүрмийн 3.1-д заасан комиссын бүрэлдэхүүнд харьяалах байгууллагын төлөөллийг оролцуулна.
- 3.5. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдэд урамшуулал олгоно.

- 3.6. Дүрмийн 3.1, 3.2, 3.13-д заасан комисс осолдогчийг нийгмийн даатгалд хамрагдсан эсэхийг үл харгалзан энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтаар баталсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт" (цаашид "акт" гэх)-ын дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэнэ.
- 3.7. Комисс нь шаардлагатай тохиолдолд осол, хурц хордлогын талаар тухайн чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн болон хяналтын бусад улсын байцаагч, ажил олгогчоос хараат бус мэргэжилтэн, шинжээч болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулж болно.
- 3.8. Комисс нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарснаас хойш 48 цагийн дотор судлан бүртгэх бөгөөд актыг үйлдэж комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдгийг дарна.

- 3.9. Ажил олгогч үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан хөдөлмөрийн хяналтын болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид актыг хүргүүлнэ.
- 3.10. Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн актыг хөдөлмөрийн хяналтын, хурц хордлогыг судлан бүртгэсэн актыг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч ажлын 5 хоногт багтаан тус тус хянан баталгаажуулна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч тусгайлан дүгнэлт гаргана. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч ослыг судлан бүртгэхэд шаардагдах зардал (тээвэр, холбоо гэх мэт)-ыг ажил олгогч хариуцна.
- 3.11. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судалж бүртгэсэн акт, дүгнэлтийг 4 хувь үйлдэж, харьяа нийгмийн даатгалын хэлтэс, орон нутгийн хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судалж бүртгэсэн актыг осолдогч буюу түүний гэр бүлд нь өгнө.

- 3.12. Ажил олгогч болон аймаг, нийслэл, сум дүүргийн комисс акт дүгнэлтийн 1 хувийг архивын нэгж болгон хадгална.
- 3.13. Ноцтой, хор аюул, хохирол ихтэй үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд Засгийн газраас тухай бүрт нь томилсон комисс судлан бүртгэнэ.
- 3.14. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас ажилтны эрүүл мэндэд хүнд гэмтэл, бэртэл учирсан, нас барсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын шинжилгээ, магадлагаа шаардлагатай бол үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг ажлын 21 хоногийн дотор судлан бүртгэнэ.

Дөрөв. Комиссын эрх, үүрэг

- 4.1. Комисс нь дараах эрхтэй байна:
- 4.1.1. үйлдвэрлэл, үйлчилгээний болон ажлын байранд нэвтрэн орж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нөхцөл байдалтай биечлэн танилцах;
- 4.1.2. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нөхцөл байдлын улмаас шаардлагатай тохиолдолд зөвлөгөө, тусламж авах зорилгоор мэргэжилтэн, шинжээч оролцуулах, ослын талаар техникийн тооцоо, лабораторийн шинжилгээ, туршилт хийлгүүлэх, осол гарсан ажлын байрны эрсдэлийн үнэлгээ дахин хийж, дүгнэлт гаргуулах;
- 4.1.3. осолдогч болон осол, хурц хордлого гарах үед байсан гэрчийн этгээд, мэргэжилтэн, удирдах ажилтнаас тайлбар, мэдээлэл, ярилцлага авах, холбогдох бичиг баримттай танилцах;
- 4.1.4. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад шаардлагатай ажлын байр, техник хэрэгсэл, унаагаар хангуулах.

- 4.2. Комисс нь дараах үүргийг гүйцэтгэнэ:
- 4.2.1. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, судлан бүртгэх үйл ажиллагааг эхлүүлэх;
- 4.2.2. үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахад хүргэсэн, бусад ажилтны эрүүл мэндэд аюул эрсдэл учруулах, ажлын байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орчны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл, нөхцөл байдлыг арилгах арга хэмжээг аюулгүй шуурхай зохион байгуулах талаар ажил олгогчид шаардлага тавих, зөвлөмж өгөх;
- 4.2.3. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад гарсан гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, ажлын 5 хоногийн дотор магадлан шалгаж, шийдвэрлэх;
- 4.2.4. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлан бүртгэсэн акт, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, зөвлөлтэй хамтран нийт ажилтнуудад осол, хурц хордлого гарсан нөхцөл байдал, шалтгааны талаар болон урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл өгөх арга хэмжээг нэн даруй авах.

Тав. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд бүрдүүлэх бичиг баримт

- 5.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
 - 5.1.1. Осолдогч тус бүрээр гаргасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын акт;
 - 5.1.2. Осолдогчоос авсан тайлбар, тодруулсан ярилцлагын тэмдэглэл, осолдогч нас барсан тохиолдолд гэрчийн тодорхойлолт, түүний ярилцлагын тэмдэглэл;
 - 5.1.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байр, тоног төхөөрөмж, техник, багаж хэрэгслийн гэрэл зураг болон бүдүүвч зураг, схем, дүрс бичлэг;

- 5.1.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбоотой асуудлаар холбогдох хүмүүсээс авсан мэдээлэл, ярилцлагын тэмдэглэл;
- 5.1.5. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн осолдогчийн ажилд орсон тухай шийдвэр, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, аюулгүй ажиллагааны зааварчилгааны бүртгэл, сургалтад хамрагдсаныг гэрчлэх зэрэг баримтын хуулбар;
- 5.1.6. Осолдогчид олгосон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн баримтын хуулбар;
- 5.1.7. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар тухайн гарсан осол, хордлоготой холбоотой холбогдох дүрэм, журам, зааврын хуулбар;
- 5.1.8. Тухайн ажлын байранд хийсэн эрсдэлийн үнэлгээний хуулбар;
- 5.1.9. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай яаралтай мэдэгдэх хуудас;

- 5.2. Энэ дүрмийн 3.14-т заасан тохиолдолд дараах бичиг баримтыг актанд хавсаргана.
- 5.2.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын зэрэг, эмнэлгийн болон мэргэжлийн байгууллагын шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээ, туршилтын дүн;
- 5.2.2. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт (дүгнэлт гарсан тохиолдолд);
- 5.2.3. Мэргэжлийн болон бусад холбогдох чиглэлийн хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн, шинжээч болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт (дүгнэлт гарсан тохиолдолд);
- 5.2.4. Осолдогч нас барсан тохиолдолд цогцост задлан шинжилгээ хийсэн тухай шүүх эмнэлгийн дүгнэлт;
- 5.2.5. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоосон акт.

Зургаа. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай мэдээлэх, тайлан гаргах

- 6.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай осолдогч өөрөө, эсхүл осол, хордлогыг анх харсан ажилтан, иргэн ажил олгогчид нэн даруй мэдээлнэ. Ажил олгогч болон түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас осолдогчийн эрүүл мэндэд учирсан хохирлын зэргээс үл хамааран орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад, эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан болон нас барсан бол орон нутгийн цагдаагийн байгууллагад тус тус нэн даруй мэдэгдэнэ.
- 6.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай мэдээллийг хүлээн авмагц ажил олгогч, комисс нь осолдогчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, эмнэлэгт хүргүүлнэ.
- 6.3. Ажил олгогч нь цагдаа, хөдөлмөрийн хяналтын болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагч, комисс судалгаа, шинжилгээ хийх хүртэлх хугацаанд осол, хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авна.

- 6.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авч, тухайн үеийн байдлыг хэвээр хадгалах нь бусад ажилтны эрүүл мэндэд болон ажлын байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орчны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөөр бол ажил олгогч үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухайн үеийн нөхцөл байдлыг дүрс бичлэг, гэрэл зураг болон бүдүүвч зургаар баримтжуулсан байна.
- 6.5. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай мэдээг батлагдсан маягтын дагуу тухайн орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.
- 6.6. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар ажил олгогчоос ирүүлсэн мэдээг хөдөлмөрийн хяналтын болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь батлагдсан маягтын дагуу сар бүр нэгтгэн гаргаж, дараа сарын 2-ны дотор мэргэжлийн хяналтын төв байгууллагад тус тус хүргүүлнэ.
- 6.7. Мэргэжлийн хяналтын төв байгууллага нь нэгтгэсэн тайланг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хороонд дараа сарын 5-ны дотор тус тус хүргүүлнэ.

Долоо. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбогдсон маргааныг шийдвэрлэх

- 7.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар гаргасан акт, дүгнэлтийг ажил олгогч, осолдогч болон осолдогч нас барсан тохиолдолд түүний гэр бүл нь зөвшөөрөхгүй бол гомдлоо мэргэжлийн хяналтын төв байгууллага болон шүүхэд гаргаж холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 7.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарснаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн тохиолдолд акт, дүгнэлтийг нөхөн тогтоохгүй.
- 7.3. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь комиссоос гаргасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын актыг хүлээн зөвшөөрөхгүй бол дүгнэлтээ тусад нь гаргана. Энэ тохиолдолд хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь комиссоос гаргасан акт, дүгнэлтийн баталгаажуулах хэсэгт “хүлээн зөвшөөрөөгүй” гэсэн тэмдэглэгээ хийж, овог нэрээ бичиж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарна.

Төвийн захирлын 2019.08.14-ний өдрийн А/47 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Нарийн бичиг:

Хүний нөөцийн мэргэжилтэн

Гишүүд:

Суурь бүтэц ашиглалт, объектийн гэрчилгээжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Салбарын судалгаа, олон нийтийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Дотоод үйл ажиллагааны мэргэжилтэн, нярав

2021 оны байдлаарх үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээлэл

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллээр Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого 2021 оны эхний улиралд 45 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 39 (46.4%)-н тохиолдолоор, өмнөх улирлаас 69 (59.8%) буурсан байна. Эдгээр 45 тохиолдол бүгд үйлдвэрлэлийн осол байгаа ба хурц хордлогын тохиолдол гараагүй байна.
- Үйлдвэрлэлийн ослын 14 (31.1%) тохиолдол унаж, бүдрэх, хальтарснаас үүссэн бол 8 (17.8%) нь эд зүйлд хавчуулагдах, 4 (8.9%) нь унаж байгаа эд зүйлд цохигдсоны, 4 (8.9%) нь хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөний, 3 (6.7%) нь халалт, түлэгдэлт, хөлдөлтийн, 2 (4.4%) нь гадны халдлагад өртсөний, 1 (2.2%) нь эд зүйл дээр гишгэсэн суурин болон хөдөлгөөнт эд зүйлд цохигдсоны улмаас, 9 (20.0%) нь бусад шалтгааны улмаас бүртгэгдсэн байна.
- Нийт осолдогчдын 22 (48.9%) нь хөнгөн хэлбэрээр, 19 (42.2%) хүнд хэлбэрээр осолдож, 4 (8.9%) хүн нас барсан байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын осол гарах үндсэн шалтгаан

Зохион байгуулалтын шалтгаан

Ариун цэвэр , эрүүл ахуйн шалтгаан

Сэтгэлзүй, физиологийн шалтгаан

Техникийн шалтгаан

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын осол гарах бусад шалтгаан

